

43



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 30 өдөр

Дугаар АМБ

Чойбалсан

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.18 дахь заалтууд, Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 400 дугаар тушаал, "Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс"-ын 2022 оны хоёрдугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Дорнын анир солонго" ХХК-ийн "Анир солонго" үүдэн эмнэлэг, "Моречлире" ХХК-ийн "Моречлире" үүдэн эмнэлэг, "Буйр эм тан" ХХК-ийн "Буйр эм тан" эмийн сан, "Хүслийн содон сондор" ХХК-ийн "Содон фарм" эмийн сан, "Монос Дорнод" ХХК-ийн "Монос Дорнод" эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус 5 жилийн хугацаагаар сунгаж, хавсралтаар баталсугай.

2. Хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхийг "Дорнын анир солонго" ХХК, "Моречлире" ХХК, "Буйр эм тан" ХХК, "Хүслийн содон сондор" ХХК, "Монос Дорнод" ХХК-ийн захирал нарт үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажлын алба (Ч.Оюунаа), Мэргэжлийн хяналтын газар (Д.Мөнхтуяа)-т тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Э.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

0101 1426

Аймгийн Засаг даргын 2022 оны
 0.9 дугаар сарын 20 - ны өдрийн
 4576 дугаар захирамжийн хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ ЭРҮҮЛ
 МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

№	Хуулийн этгээдийн нэр	Оноосон нэр	Байршил	Тусгай зөвшөөрлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Сунга-сан жил	Хүчинтэй хугацаа	
							Эхлэх	Дуусах
1	"Дорнын анир солонго" ХХК	"Анир солонго" үүдэн эмнэлэг	Дорнод аймаг Хэрлэн сум 7-р баг 33-р байр	ЭХ-19/09/892	Бэлгийн замаар дамжих халдварын оношилгоо, эмчилгээ, лаборатори, нийгмийн эрүүл мэндийн зөвлөгөө өгөх	5	2022.07.26	2027.07.26
2	"Моречлире" ХХК	"Моречлире" үүдэн эмнэлэг	Дорнод аймаг, Хэрлэн сумын 7-р баг Эмнэлгийн бүс Т хэлбэрийн байрны баруун талын хойд хэсэг	ЭХ-16/09/820	Хиймэл шүд хийх тусламж үйлчилгээ	5	2022.08.19	2027.08.19
3	"Буйр эм тан" ХХК	Буйр эм тан" эмийн сан	Дорнод аймаг, Хэрлэн сум 6-р баг "Талын шилтгээн" хотхон 5-р байр	ЭСХ-19/09/894	Эмийн сан II зэрэглэл	5	2022.09.20	2027.09.20
4	"Хүслийн содон сондор" ХХК	Содон фарм" эмийн сан	Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг үйлчилгээний төвийн хойд талаас	ЭСХ-19/09/897	Эмийн сан II зэрэглэл	5	2022.12.05	2027.12.05
5	"Монос Дорнод" ХХК	"Монос Дорнод" эмийн сан	Дорнод аймаг Хэрлэн сум 6-р баг Хэрлэн номин бизнес худалдааны төв	ЭСХ-19/05/890	Эмийн сан II зэрэглэл	5	2022.11.21	2027.11.21